



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 8 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил

Утас: 77665858

Цахим хаяг: Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangaiaudit.gov.mn

2025.02.25 № 91

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 9 арга хэмжээнд төсвөөс 1,029,075.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэл 87.3 хувь буюу 896,286.8 мянган төгрөгийг зарцуулж, 122,889.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 8-р цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 үндсэн зорилтын хүрээнд 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	115,859,460.01	160,653,158.26
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	75,724,089.45	122,889,309.70
312	Банканд байгаа бэлэн мөнгө	75,724,089.45	122,889,309.70
3121	Төгрөг	75,724,089.45	122,889,309.70
31211	Төрийн сангийн харилцах	75,724,089.45	122,889,309.70
35	БАРАА МАТЕРИАЛ	40,135,370.56	37,763,848.56
354	Хангамжийн материал	40135,370.56	37,763,848.56
3541	Бичиг хэргийн материал	512,000.00	367,000.00
3542	Аж ахуйн материал	39,139,370.56	36,912,848.56
35440	Барилгын засварын материал	484,000.00	484,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	366,979,863.78	375,340,309.26
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	366,979,863.78	375,340,309.26
392	Биет хөрөнгө	336,993,613.78	345,601,559.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	346,372,982.44	348,976,982.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-41,245,837.02	-51,595,629.30
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	58,008,796.80	84,806,296.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-34,111,466.91	-42,373,111.28
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,696,146.18	33,696,146.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	-27,671,908.51	-29,854,026.38
39217	Ном	1,944,900.80	1,944,900.80
393	Биет бус хөрөнгө	29,986,250.0	29,738,750.0
39301	Программ хангамж	2,117,500.0	2,117,500.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,581,250.0	-1,828,750.0
39303	Бусад биет бус хөрөнгө	29,450,000.0	29,450,000.0
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	482,839,323.79	535,993,467.52
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,769,164.0	800,000.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,769,164.0	800,000.0
413	Өглөг	1,769,164.0	800,000.0
4136	Бусад өглөг	514,374.0	
41361	Байгууллагад төлөх өглөг	1,254,790.0	800,000.0
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	481,070,159.79	535,193,467.52
51	Засгийн газрын хувь оролцоо	481,070,159.79	535,193,467.52
511	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	356,921,047.43	356,921,047.43
512	Хуримтлагдсан үр дүн	36,406,367.35	90,529,675.08
5121	Өмнөх үеийн үр дүн	36,406,367.35	36,406,367.35
5122	Тайлант үеийн үр дүн		54,123,307.73
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	87,742,745.01	87,742,742.01
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	482,839,323.79	535,993,467.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	751,507,329.30	972,149,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,172,229.30	18,937,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,172,229.30	18,937,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,172,229.30	18,937,500.00
1200042	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	7,067,229.30	18,797,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	744,335,100	953,211,800
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	676,461,700	874,826,700
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	676,461,700	874,826,700
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	676,461,700	874,826,700
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,873,400	78,385,100
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,873,400	78,385,100
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	668,015,674.95	918,025,992.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	668,015,674.95	918,025,992.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	654,677,841.06	910,966,228.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	424,623,956.77	624,029,953.55
210101	Үндсэн цалин	304,160,523.48	426,642,532.22
210102	Нэмэгдэл	103,043,552.29	168,868,565.46
210104	Урамшуулал	17,419,881.00	28,518,855.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,420,378.73	81,793,400.0
210201	Тэтгэврийн даатгал	35,337,797.06	55,619,600.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,788,259.88	6,543,400.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,030,609.08	3,271,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	751,209.03	3,271,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,512,503.68	13,087,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,647,050.11	61,075,335.94
210301	Гэрэл, цахилгаан	6,212,343.11	7,379,995.0
210302	Түлш, халаалт	42,979,834.0	48,858,167.0
210303	Цэвэр, бохир ус	4,454,873.0	4,837,173.94
2105	Нормативт зардал	87,734,695.0	90,619,079.20
210502	Хоол, хүнс	87,734,695.0	90,619,079.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,286,000.0	7,646,000.0
210604	Урсгал засвар	4,286,000.0	7,646,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,168,800.0	2,840,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,168,800.0	2,840,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,796,960.45	42,962,459.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,133,560.0	21,771,405.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,257,900.0	150,000.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,405,500.45	21,041,054.52
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,337,833.89	7,059,764.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,396,300	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,941,533.89	7,059,764.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	83,491,654.35	54,123,307.73
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	83,491,654.35	54,123,307.73

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	744,440,100.0	953,351,800.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,000.0	140,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	105,000.0	140,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.0	140,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.0	140,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	744,335,100.0	953,211,800.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	676,461,700.0	874,826,700.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	676,461,700.0	874,826,700.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,873,400.0	78,385,100.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,873,400.0	78,385,100.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	668,827,356.50	895,582,579.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	668,827,356.50	895,582,579.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	655,489,522.61	888,522,815.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	424,623,956.77	624,029,953.55
210101	Үндсэн цалин	303,898,951.98	426,642,532.22
210102	Нэмэгдэл	103,305,123.79	168,868,565.46
210104	Урамшуулал	17,419,881	28,518,855.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,420,378.73	81,793,400.0
210201	Тэтгэврийн даатгал	35,337,797.06	55,619,600.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,788,259.91	6,543,400.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,030,609.08	3,271,700.0
210204	Ажилгүйдлийн даатгал	751,209.03	3,271,700.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,512,503.65	13,087,000.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,931,866.11	61,075,335.94
210301	Гэрэл, цахилгаан	6,212,343.11	8,238,162.0
210302	Түлш, халаалт	50,264,650.0	48,000,000.0
210303	Цэвэр, бохир ус	4,454,873.0	4,837,173.94
2105	Нормативт зардал	90,271,521.0	91,074,203.20
210502	Хоол, хүнс	90,271,521.0	91,074,203.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.0	7,646,000.0
210604	Урсгал засвар	5,000,000.0	7,646,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,168,800.0	2,840,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,168,800.0	2,840,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,073,000.0	20,063,923.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,566,500.0	14,197,523.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,506,500.0	5,866,400.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,337,833.89	7,059,764.06
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,396,300.0	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,941,533.89	7,059,764.06
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	75,612,743.50	57,769,220.25
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		10,604,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-10,604,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	75,612,743.50	47,165,220.25
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	111,345.95	75,724,089.45
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	75,724,089.45	122,889,309.70

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,921,047.43	87,742,745.01	36,406,367.35	481,070,159.79
9	Тайлант үеийн үр дүн			54,123,307.73	54,123,307.73
10	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	356,921,047.43	87,742,745.01	90,529,675.08	535,193,467.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,029,075,800.00	899,126,815.69	129,948,984.31	87.3
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,029,075,800.00	899,126,815.69	129,948,984.31	87.3
210	Бараа, үйлчилгээний зардал	1,029,075,800.00	899,126,815.69	129,948,984.31	87.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	737,993,600.00	624,029,953.55	113,963,646.45	84.6
210101	Үндсэн цалин	524,698,800.00	426,642,532.22	98,056,267.78	81.3
210102	Нэмэгдэл	200,287,400.00	168,868,565.46	31,418,834.54	84.3
210104	Урамшуулал	13,007,400.00	28,518,855.87	(15,511,455.87)	219.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,155,500.00	81,793,400.00	3,362,100.00	96.1
210201	Тэтгэврийн даатгал	57,907,600.00	55,619,600.00	2,288,000.00	96.0
210202	Тэтгэмжийн даатгал	6,810,600.00	6,543,400.00	267,200.00	96.1
210203	ҮОМШӨ ний даатгал	3,406,100.00	3,271,700.00	134,400.00	96.1
210204	Ажилгүйдлийн даатгал	3,406,100.00	3,271,700.00	134,400.00	96.1
210205	Эрүүл мэндийн даатгал	13,625,100.00	13,087,000.00	538,100.00	96.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	68,135,100.00	61,075,335.94	7,059,764.06	89.6
210301	Гэрэл цахилгаан	10,847,100.00	8,238,162.00	2,608,938.00	75.9
210302	Түлц, халаалт	48,000,000.00	48,000,000.00	-	100.0
210303	Цэвэр, бохир ус	9,288,000.00	4,837,173.94	4,450,826.06	52.1
2105	Нормативт зардал	93,760,600.00	91,074,203.20	2,686,396.80	97.1
210502	Хоол, хүнс	93,760,600.00	91,074,203.20	2,686,396.80	97.1
2106	Эд хогшил худалдан авах	10,250,000.00	10,250,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,250,000.00	10,250,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,863,100.00	2,840,000.00	23,100.00	99.2-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,863,100.00	2,840,000.00	23,100.00	99.2
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	30,917,900.00	28,063,923.00	2,853,977.00	90.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,051,500.00	19,197,523.00	2,853,977.00	87.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	8,866,400.00	8,866,400.00	-	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,029,075,800.00	946,292,035.94	82,783,764.06	92.0
132001	Улсын төсвөөс санхүүжих	874,826,700.00	874,826,700.00	00.00	92.0
	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	78,385,100.00	71,325,335.94	7,059,764.06	
	Орон нутгийн төсвөөс	78,385,100.00	71,325,335.94	7,059,764.06	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	75,864,000.00	140,000.00	75,724,000.00	0.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000.00	140,000.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	75,724,000.00	-	75,724,000.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	75,724,089.45	(75,724,089.45)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	122,889,309.70	(122,889,309.70)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.00	25.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	207.00	207.00	-	100.0
631	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	207.00	207.00	-	100.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	207.00	207.00	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа залруулаагүй. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 зөрчил¹ илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Тайлант онд хоолны зардлаас ахуйн хэрэглээний төлбөрт 587.5 мянган төгрөгийг шилжүүлж, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

3.2.1 Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой.

Илрүүлэлт: 1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй;

2. Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр программд оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Зөвлөмж: Иймд аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, цаашид нягтлан бодох бүртгэлийн программд бараа материалын гүйлгээг тухай бүртгэх, анхан шатны баримтыг программаар боловсруулах, хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бэлтгэж үр дүнг санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "... албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан тул зөвлөмжийн төлөвлөгөөг 2025.03.25-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлж ажиллана уу.

Энэхүү зөвлөмжийн төлөвлөгөөг ирүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасан ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохыг анхааруулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Зориулалт бус	1	587.5			1	587.5						
Бараа материал, програмтай холбоотой	2	0					2	0				
Дүн	3	587.5			1	587.5	2	0				